

Агуу Үнэт Сувдаас өөр Библийн Иосеф Смитийн Орчуулгыг хаанаас олохоо та мэдэх үү? Дийлэнх нь судрын арын хэсэгт байрлах Библийн Иосеф Смитийн Орчуулгын түүвэрт эсвэл Gospel Library аппликэйшны Судлах тусламж хэсэгт байгаа Иосеф Смитийн Орчуулгын хавсралтад байдаг. Доор байгаа жишээ, тайлбарыг харж; эдгээр эх сурвалжийг хэрхэн ашиглах талаар олж мэд.

БИБЛИЙН ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГААС АВСАН ТҮҮВРҮҮД

Библийн Хаан Жеймсийн хувилбараас Иосеф Смитийн орчуулсан (ИСО) хэсгүүдийн түүврийг дор харуулав. Анхны үгс бичигдсэнээс хойш алга болсон буюу өөрчлөгдсөн үгнүүдийг Библийн эх сэдэвт сэргээхэд Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитийг урамшуулжээ. Эдгээр сэргээгдсэн үгнүүд сургаалыг тодосгож, судруудыг ойлгох явдлыг сайжруулсан байна. Удирдамжид сонгож авсан хэсгүүд нь ямар хэлэнд орчуулагдсанаас үл хамааран судруудын талаарх та бүхний ойлголтыг сайжруулахад туслах болно.

Анхны зохиогчдын нэгэнт цэдэглэсэн үгнүүдийг Их Эзэн Иосеф Смитэд илчилсэн учир, Иосеф Смитийн орчуулга нь дэлхий дэх Библийн өөр ямар ч орчуулгатай адилгүй юм. Энэ утгаараа, орчуулга гэдэг үг ердийнхөөсөө илүү өргөн хийгээд өөр байдлаар хэрэглэгддэг, учир нь Иосеф Смитийн орчуулга бол ердөө л нэг хэлнээс нөгөөд хөрвүүлсэн орчуулга гэхээс илүү илчлэлт байлаа. ИСО-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Удирдамж дахь цагаан толгойн дэс дарааллаарх сэдвийн жагсаалт дахь Иосеф Смитийн Орчуулгаас үз.

ИСО-аас авсан түүврийн загварыг дор харуулав:

Түүний орчуулга Библийн эх сэдэвт үгсийг сэргээсэн учир шүлгүүдийн дугаар нь таны ашиглаж буй хэвлэлийнхээс өөр байж болно.

ИСО, Матай 4:1, 5–6, 8–9 (Матай 4:1, 5–6, 8–9-тэй харьцуул; мөн үүнтэй адил өөрчлөлтүүд Лук 4:2; 5–11-д хийгджээ). Иосеф Смитийн орчуулгатай таны харьцуулах ёстой Библийн ишлэл хаалтан дотор байгаа болно.

(Есүс Сатанаар биш, Сүнсээр хөтлөгдөв.)

1 Тийнхүү Есүс Бурхантай хамт байхаар цөл уруу Сүнсээр хөтлөгдөв.

5 Тэгээд Есүс ариун хотод аваачигдан, мөн Сүнс түүнийг ариун сүмийн орой дээр тавив.

6 Тэгтэл чөтгөр түүн дээр хүрч ирэн хэлсэн нь, Хэрэв чи Бурханы хүү юм бол, өөрийгөө доош хая; учир нь энэ нь бичигдсэн билээ, Тэрээр чиний талаар тэнгэр элчүүддээ санаа тавихыг үүрэг өгөх болно; мөн ямар ч үед чи хөлөөрөө чулуу өшиглөхгүйн тулд тэд чамайг гар дээрээ авч явах болно.

8 Мөн дахин, Есүс Сүнсэн дотор байв, мөн энэ нь түүнийг үлэмж өндөр ууланд аваачиж, тэгээд дэлхийн бүх хаант улсууд хийгээд тэдгээрийн алдар сууг түүнд харуулав.

9 Мөн чөтгөр түүн дээр дахин хүрч ирэн, эдгээр бүх зүйл байх болно хэмээн хэлэв.

Тод үсгээрх ишлэл нь Хаан Жеймсийн Библиэс Иосеф Смитийн хийсэн орчуулгын хэсэг юм.

Энэхүү нотолгоо нь Иосеф Смит өөрийнхөө орчуулгаар ямар сургаалыг тодруулсныг тайлбарладаг.

Энэ бол Иосеф Смитийн орчуулсан эх сэдэв юм.

Зарим хэлэнд, Иосеф Смитийн Орчуулгын хэсгүүдийг Библийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувилбар дээрх зүүлт тайлбар хэсгээс эсвэл дижитал төхөөрөмжүүд дээрээс “Холбоотой агуулга” гэсэн хэсгээс олж болно.

Библийн дараах хэсгүүдийг уншаад, Иосеф Смитийн Орчуулгыг ашиглан сүнслэгээр өдөөгдөн гарсан өөрчлөлтүүдийг олж тогтоо.

Иохан 1:16–18 (Иосеф Смитийн Орчуулга, Иохан 1:16–19)

Иохан 4:24 (Иосеф Смитийн Орчуулга, Иохан 4:26)

Иохан 6:44

- Эдгээр сүнсний өдөөлтөөр гарч ирсэн өөрчлөлт Есүс Христийн тухай танд юу зааж байна вэ?
- Эдгээр зүйлийг илүү сайн ойлгох нь яагаад адислал байдаг вэ?